


Өвчтөнг үнэл

Уушгины хатгааны ямар нэгэн шинж тэмдэг байна уу: халуурах, ханиалгах, амьсгал давчдах, амьсгалын гачаал, өрөөний агаарт SpO₂<90%, хөхрөх, ухаан санаа самуурах, ухаан санааны байдал муудах, эсвэл амьсгалын тоо олшрох (нас: 2 сараас бага бол ≥60, 2-11 сар ≥50, 1-5 нас ≥40, 5-15 нас ≥30, 16-аас дээш нас >22)



Үргэлжлүүлэн хяна, давтан үнэл (2-4 цаг тутамд)
Өвчтөн эмчилгээний зорилгыг хангаж байна уу?

- SpO₂ (>90%),
- Амьсгалын ажил буурч буй,
- pH > 7.30,
- PaCO₂ < 45,
- Ухаан санааны байдал хэвийн

Хэрэв үгүй бол эмчилгээний өөр сонголт, эмчилгээний хүрээг нэмэгдүүлэх, эсвэл дараагийн шатанд шилжүүлэх талаар бодолц

Хүчилтөрөгчийн титр ба SpO₂ зорилт

- Хүүхэд, насанд хүрэгчдэд **SpO₂ ≥ 90%**
- Жирэмсэн эхчүүдэд **SpO₂ ≥ 92-95%**
- Олон эрхтэний дутагдлын шинжтэй хүүхэд, насанд хүрэгчдэд **SpO₂ ≥ 94%**
- SpO₂ > 96% үед гаж нөлөөнөөс сэргийлж хүчилтөрөгчийн дэмжлэгийг эргэн хар

Нэмэлтээр

- Халдвар хамгаалал, хувийн хамгаалах хэрэгслийн журмыг мөрд
- Аэрозол, дуслын эрсдлийг бууруулахаар хамрын гуурс, өндөр урсгалт хүчилтөрөгчийн канюлийн дээгүүр **мэс заслын маск** зүүлгэ
- **Түрүүлэг нь харуулах**
- Амьсгалын замын нээлттэй байдлыг хадгалах (мөрийг тэнийлгэх, эрүү өргөх)
- Орны толгойг өргөх
- Амьсгалын физик эмчилгээ
- Ам, хамраар соруулга хийх

Интубаци тавьж зохиомол амьсгалд авах талаар бодолц*
Уушги хамгаалах амьсгал (***)
Эсвэл
Амьсгалыг аюулгүй удирдах тасагт АМБУ-аар амьсгал дэмжиж (амьсгалын дутагдлын үед) хүргэх

Амь насанд аюултай шинжүүд

- Амьсгал саадтай, эсвэл хангалтгүй
- Төвийн хөхрөлт
- Хүнд хэлбэрийн амьсгалын дистресс (амьсгалын тоо олширсон, амьсгалд туслах булчингийн оролцоо их)
- Шокийн шинжүүд
- Ухаан санааны байдал аюултайгаар муудсан
- Таталт
- Ацидоз (pH < 7.30)
- Хүчилтөрөгчийн хүнд хэлбэрийн дутагдал (PaO₂/FiO₂ < 100)

СРАР, инвазив бус дэмжлэгийн эсрэг заалт

- Аспирацийн эрсдэлтэй
- Амьсгалын замаа өөрөө хамгаалах, маскийг авах чадваргүй
- Цус эргэлт тогтворгүй
- Ухаан санааны байдал муудсан
- Яаралтай интубаци шаардлагатай
- Маск байрлуулахад анатомийн хувьд төвөгтэй /харьцангуй/
- Өөрийн амьсгалын оролдлого хангалтгүй

* Эмчийн клиник дүгнэлт болон эрсдэл/ац холбогдлын үнэлгээ хийж тухайн өвчтөнд тохирсон хүчилтөрөгч өгөх аргачлалыг сонгоно. Мөн түүнчлэн тухайн улсын болон олон улсад байгаа нотолгоо, хүчилтөрөгчийн хангалт, мэргэжилтний ур чадвар, хэрэгсэл, хяналтын хүртээмж зэргийг бодолцох ёстой.

** Вентури нүүрний маск нь урсгалын хурд, мөн тохируулгаас шалтгаалан FiO₂ 24-60% хүргэнэ.

EPAP (амьсгал гаргалтын эерэг даралт), PS (даралтаар дэмжих), UAӨӨ (архаг бөглөрөлттэй уушгины эмгэг), SpO₂ (хүчилтөрөгч хангалт), PaCO₂ (артерийн цусанд дхь нүүрс хүчлийн хийн парциаль даралт), PaO₂/FiO₂ (артерийн цусны хүчилтөрөгчийн парциаль даралт болон амьсгалж буй агаарын хүчилтөрөгчийн концентрацийн харьцаа), CPAP (амьсгалын замын үргэлжилсэн эерэг даралт), bCPAP (бөмбөлөгт CPAP - нярайд өгөх CPAP-ын нэг төрөл), NIPPV (инвазив бус эерэг даралтат амьсгалуулалт), BiPAP (хоёр төвшинт эерэг даралтат амьсгал)